

Golomt Capital®

Хөрөнгийн зах зээлийн ТОЙМ

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.04.04

Олон улсын
хөрөнгийн зах зээл

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Онцлох индексүүдийн өөрчлөлт

Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтүүдийг үзүүлэв. Үүнд, АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.

Америкийн индекс	Одоогийн ханш	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dow Jones	\$34,818.27	\$34,698.95	0.34%	\$33,594.34	3.64%	\$33,527.19	3.85%
S&P 500	\$4,545.86	\$4,542.16	0.08%	\$4,350.71	4.49%	\$4,077.91	11.48%
Nasdaq	\$14,261.50	\$14,263.73	-0.02%	\$13,602.30	4.85%	\$13,705.59	4.06%

Европын индекс	Одоогийн ханш	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dax	€ 14,446.48	€ 14,467.99	-0.15%	€ 13,860.31	4.23%	€ 15,107.17	-4.37%
FTSE 100	£7,537.90	£7,503.52	0.46%	£7,329.54	2.84%	£6,737.30	11.88%

Азийн индекс	Одоогийн ханш	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
CSI 300	¥4,276.16	¥4,100.65	4.28%	¥4,571.26	-6.46%	¥5,110.78	-16.33%
Hang Seng	HKD 22,039.55	HKD 21,232.41	3.80%	HKD 22,534.91	-2.20%	HKD 28,938.74	-23.84%
Nikkei 225	JPY 27,665.98	JPY 28,002.51	-1.20%	JPY 26,537.75	4.25%	JPY 29,388.87	-5.86%

Индексийн өөрчлөлт



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

TESLA КОМПАНИ ЭХНИЙ УЛИРАЛД 310,048 ЦАХИЛГААН АВТОМАШИН НИЙЛҮҮЛЖЭЭ

АНУ-ын Tesla компаниас 2022 оны эхний улирлын автомашин үйлдвэрлэлт, нийлүүлэлтийн тоог мэдээлэв.

Шинжээчид тус компанийн эхний гурван сарын нийт борлуулалтыг 278,000-аас 357,000 болно гэж таамаглаж байсан бол ойролцоогоор 310,048 автомашин нийлүүлж 305,407 цахилгаан автомашин үйлдвэрлэжээ.


Энэ нь өмнөх улиралд үйлдвэрлэсэн цахилгаан автомашинаас 4,641-ээр цөөн байгаа нь "нийлүүлэлтийн сүлжээнд тулгарч буй бэрхшээл, үйлдвэрүүд зогсонги байдалд орсонтой холбоотой" гэж Tesla-гаас мэдээлсэн.

Өнгөрсөн жилийн нэгдүгээр улиралд Tesla компани нийт 184,800 цахилгаан автомашин нийлүүлж, 180,338 цахилгаан автомашин үйлдвэрлэсэн нь ойролцоогоор 68.55 хувийн өсөлт байсан юм.

Нийт борлуулалтын 95 хувь буюу 295,324 ширхэг нь Model 3 болон Model Y загварын автомашинууд байсан.

Тус компани саяхан Германы Бранденбург хотод шинэ үйлдвэрээ нээж, 3 сарын 22-нд тууз хайчилсан. Мөн 4 сарын 7-нд Техас мужийн Остинд шинэ автомашин үйлдвэрийн нээлтээ хийхээр төлөвлөж байна.

Нийт нийлүүлэлт



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ОХУ болон барууны орнууд Украины дайнд Энэтхэгийг өөрсдийн талд оруулахаар тэмцэж байна

ОХУ Украин улс руу довтолсноос хойш ОХУ болон барууны орнуудын хооронд улс төрийн томоохон мөргөлдөөн үүссэн. Энэ дайнд аль аль тал нь дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн болох БНХАУ, Энэтхэгийг өөрсдийн талд оруулахаар зүтгэж байна.

ОХУ, Их Британийн зүгээс пүрэв гарагт Гадаад хэргийн сайд нараа Энэтхэг рүү илгээж, Энэтхэгийн ерөнхий сайд Нарендра Модиг дайн болон арилжааны тал дээр өөрсдийн талд оруулах ятгалгыг хийсэн байна.

Албан ёсны айлчлалын өмнө Их Британийн Гадаад хэргийн сайд Лиз Трасс Дели хотын засаг захиргаанд "Их Британи, Энэтхэгийн харилцааг гүнзгийрүүлэх нь Ази Номхон далайн бүс нутаг болон дэлхийн хэмжээнд энх тайвныг сахиулж, ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг боломжийг нээх нь Орос Украин руу шалтгаангүйгээр довтолсноос чухал асуудал юм" гэжээ.

Харин ОХУ-ын Гадаад хэргийн сайд Сергей Лавров Энэтхэгтэй дипломат харилцаагаа сайжруулж, илүү их газрын тос борлуулахыг эрмэлзэж байна.

Лхагва гарагт АНУ-ын шилдэг зөвлөхүүдийн нэг Далеп Сингх Энэтхэгт зочилж "ОХУ-ын Украины эсрэг хийсэн үндэслэлгүй дайны үр дагавар, дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хэрхэн бууруулах талаар зөвлөлдөх" зорилгоор хоёр өдрийн айлчлал хийжээ.

Барууны орнуудын ОХУ-ын эсрэг тавьсан хориг арга хэмжээний дараа ОХУ Азийн бусад улс орнуудтай хамтран ажиллаж, хохирлоо багасгахыг оролдож байгаа ч АНУ болон Европын Холбоо үүнийг таслан зогсоохыг эрмэлзэж байна.

Барууны орнууд ОХУ-аас эрчим хүчний импортоо эрс багасгахыг эрмэлзэж байхад Энэтхэг сүүлийн хэдэн долоо хоногт ОХУ-ын нефтийг хямд үнээр худалдан авч байна.

Тус улс төсөвтөө нэг баррель нефтийн үнийг 75 орчим ам.доллараар худалдан авахаар тусгасан. Дайны улмаас нефтийн үнэ 100 ам.доллар давсан нь Энэтхэг улсыг ОХУ-тай харилцаагаа тасалж чадахгүй байх бас нэг шалтгаан болж байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning March 28, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close		
http://eps.sh/cal										© 2022 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning April 04, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close		
http://eps.sh/cal										© 2022 Earnings Whispers	

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.